



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 10 өдөр

Дугаар А/131

Хэрлэн сум

Хүндэтгэл үзүүлж,  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хэнтий аймгийн харъяат Цагдаагийн ерөнхий газрын дарга, хошууч, генерал Жамсрангийн Болд, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын харъяат Улсын начин Бадарчийн Батбаяр нарт хүндэтгэл үзүүлэхэд 2.800.000 (хоёр сая найман зуун мянган) төгрөгийг хөрөнгө зарцуулсугай.

2. Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010350

Аймгийн Засаг даргын 2022 оны  
07 дугаар сарын 19 өдрийн  
А/З/З захирамжийн хавсралт

Хөрөнгө зарцуулалтын тооцоо

| № | Зардлын нэр       | Тоо<br>хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт дүн  |
|---|-------------------|---------------|-------------|-----------|
| 1 | Хүндэтгэл үзүүлэх | 2             | 1100.000    | 2.200.000 |
| 2 | Мөнгөн аяга       | 2             | 230.000     | 460.000   |
| 3 | Батламж           | 2             | 70.000      | 140.000   |
|   | Дүн               |               |             | 2.800.000 |